



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/433

Улаанбаатар хот

Улсын үзлэг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14.1.17, 41.2.2, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.1, 32 дугаар зүйлийн 32.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах улсын үзлэгийг дүүргийн нутаг дэвсгэрт эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, байгууллагуудын хүрээнд 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн дотор зохион байгуулсугай.

2.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үзлэг зохион байгуулах удирдамжийг хоёрдугаар, зарцуулагдах төсвийн тооцоог гуравдугаар хавсралтаар баталсугай.

3.Улсын үзлэгт шаардагдах 1,520,000 (нэг сая таван зуун хорин мянга) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Тамгын газар (Б.Нарангэрэл)-т зөвшөөрсүгэй.


4.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцон ажиллахыг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан төслийн удирдагч (Д.Жаргалсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.СУМЪЯАБААТАР


Баянгол дүүргийн Засаг даргын
2021 оны 10 дүгээр сарын 20-ны өдрийн
1/433 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



УЛСЫН ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Д.Жаргалсүрэн	(Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөлийн дарга)
Гишүүд	Д.Баасандорж	(Мэргэжлийн хяналтын хэлтсийн Хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч)
	Б.Батцэцэг	(Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн)
Нарийн бичгийг дарга:	Э.Нямжав	(Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан)
	Н.Хангалсүрэн	(Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн)

Баянгол дүүргийн Засаг даргын
2021 оны 10 дүгээр сарын 10-ны өдрийн
А./дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт
433



**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН УЛСЫН ҮЗЛЭГИЙГ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ
АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮРЭЭНД
ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

2021 оны 10 дугаар сарын 15

Улаанбаатар хот

Нэг. Зорилго:

Энэхүү улсын үзлэгийн зорилго нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж хэрхэн хэрэгжиж байгаатай газар дээр нь танилцах, судалгаа хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд арга зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгуулахад чиглэгдэнэ.

Хоёр. Хамрах хүрээ:

Улсын үзлэгт дүүргийн нутаг дэвсгэрт эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, байгууллага хамрагдана.

Гурав. Үзлэг зохион байгуулах бүрэлдэхүүн, хугацаа:

Дүүргийн Засаг даргын орлогч, холбогдох хэлтсүүд, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтсийн хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч зэрэг бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж, удирдамжийн холбогдох зардлын төсвийг Дүүргийн Засаг даргын захирамжаар батлуулан хэрэгжүүлж ажиллана.

Улсын үзлэгийг 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 29-ны өдрийг хүртэлх хугацаанд багтаан зохион байгуулна.

Дөрөв. Үзлэгийн явцад танилцах асуудлын чиглэл:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, ажилтны талаарх хуулийн хэрэгжилт /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь заалт/;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх ажил олгогчийн эрх, үүргийн хэрэгжилт /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйл/;
- Үйлдвэрлэлийн явцад бий болсон хими, физик, биологийн хүчин зүйл нь ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй

- байх нөхцөлийг бүрдүүлэх, техник, зохион байгуулалтын арга хэмжээ авах /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1/;
- Эрчим хүчний салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад ашиглаж байгаа машин механизм, тоног төхөөрөмжийн аюулгүй үйл ажиллагааны талаар /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 9 дүгээр зүйл/;
- Галын аюулгүй байдалд тавих шаардлага /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 13 дугаар зүйл/;
- Ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулах талаар /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйл/;
- Ажилтны ажлын хувцас, хамгаалах хэрэгслээр хангах /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйл/;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлд тавигдах шаардлага /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 16 дугаар зүйл/;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын талаарх хуулийн заалтын хэрэгжилт /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 17 дугаар зүйл/;
- Хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах иргэн, ажилтны эрх, үүргийн хэрэгжилт /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 18 дугаар зүйл/;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээний санхүүжилт /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйл/;
- Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаар /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 29 дүгээр зүйл/;
- Хөдөлмөрийн нөхцөлд хийсэн эрүүл ахуйн хэмжилт шинжилгээ, үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 31 дүгээр зүйл/;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр аж ахуй нэгж, байгууллагын дотоод хяналтын хэрэгжилт /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 35 дугаар зүйл, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 4.1.4/ хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд тавих хяналт шалгалт/;
- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 11 дүгээр зүйл. /Газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах 11.2.5/;
- Үйлдвэрлэлийн зориулалттай машин механизм, тоног төхөөрөмжийг суурилуулах, их засварын дараа ашиглалтад оруулахдаа мэргэжлийн хяналтын байгууллагаар хянуулж зөвшөөрөл, гэрчилгээ авсан байх; /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 9.1.3 дугаар зүйл/;

Тав. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн үзлэг, хяналт хийх аргачлал:


5.1 Улсын үзлэгийг ажлын хэсгийн гишүүд тухайн аж ахуйн нэгж, байгууллага дээр биечлэн очиж, танилцах, зөвлөн туслах аргаар зохион байгуулна. Үзлэг зохион байгуулах удирдамжийн хавсралтаар баталсан 1, 2, 3 дугаар хүснэгтийн дагуу тийм гэсэн хариултад 1 оноо, үгүй гэсэн хариултад 0 оноо тавьж үнэлнэ.

Хүснэгтийг хаалтад “дүгнэхгүй” гэсэн асуултууд нь тоон дүнгээр тайланд тусгагдана.

Зургаа. Тайлан гаргах

Тайланг 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хөгжлийн хэлтэст хүргүүлнэ.

Баянгол дүүргийн Засаг даргын
2021 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
1433 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт



ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ ХӨДӨЛМӨРИЙН
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ҮЗЛЭГ, ШАЛГАЛТ ХИЙХ
ЗАРДЛЫН ТӨСӨВ

2021 оны 10 дугаар сарын 15

Улаанбаатар хот

№	Байгууллагын нэр	Ажиллах өдөр	Тоо ширхэг	1 өдөрт явах /мөнгөн дүн, төгрөгөөр/	Нийт дүн /төгрөгөөр/
1	Түлш шатахуун	16 өдөр	3 машин	20,000	320,000
2	Хоол	16 өдөр	5 хүн	15,000	1, 200,000
Нийт дүн					1,520,000